

## Ерөнхийлөх хувиргал ба найруулан бичих чадварын хамаарал

Ц.Оюунчимэг\*

МУБИС, Архангайн Багийн Сургууль, Хүмүүнлэгийн ухааны тэнхим

### Хураангуй

Зөв сайхан найруулан бичнэ гэдэг нь илэрхийлэх гэсэн санаа бодол, юмс үзэгдлийг утга зохиолын хэлний хэм хэмжээнд бичнэ гэсэн үг юм. Энэ нь илэрхийлэх санаагаа ойлгомжтой, товч, тодорхой, үг сонголт, хэлзүйн арга хэрэглүүрийг зөв ашиглан найруулж бичихийг хэлнэ. Иймээс хэлний хувиргал нь хэлний нэгжүүдийг “хөдөлгөөнд оруулж”, харилцааны зорилго, холбосон орчинд нийцүүлэн, оновчтой найруулгаар илэрхийлж сургах хэрэглээний ач холбогдолтой юм.

*Ерөнхийлөх хувиргал* (генерализация)- гэдэг нь ихэвчлэн дээд түвшний их нэгжүүдэд хамаарах бөгөөд нийлмэл өгүүлбэр, эхийн гүн бүтэц буюу цөм санаа нь өнгөн бүтцийн өөрчлөлтийг даган хувирч байдаг онцлогтой. Иймд хэлбэр, хэв маяг, найруулгын бүтцээс шалтгаалан цөм санаа-онцолбор мэдээлэлд өөрчлөлт гардаг тул ерөнхийлөх хувиргал хэмээн үзэв.

Энэхүү судалгааны ажлаараа оюутны найруулан бичих чадварыг дэмжихийн тулд ерөнхийлөх хувиргалд суурилсан тогтолцоот даалгаврыг ажиллуулж туршсан юм. Эдгээр даалгавар нь эхийн найруулгын төрөл, хэв маяг, төрлийг өөрчлөх, дуурайн зохиох нь нэг талаас зохион бичих гол суурь болох, нөгөө талаас бусад хувиргах аргуудыг хослуулан хэрэглэх тул суралцагчдаас бүтээлчээр сэтгэх чадвар, хэлний мэдрэмжийг шаардана.

### Түлхүүр үг

Ерөнхийлөх хувиргал, найруулан бичих чадвар, эхийн хэлбэр, хэв маяг

### Удиртгал

Хэл нь хүний ухамсарт үйл ажиллагааг илэрхийлэх, түүх-соёлын туршлага болон мэдлэг эзэмших, хадгалах, дамжуулах хэрэглүүр, басхүү соёлын чухал элемент учраас харилцахуй ба нийгэмшихүйн үндэс болно.

Хэлэхүй нь хэрэглээ талаасаа найруулга зүйтэй холбоотой бөгөөд түүнээс хамаарч яриа, бичгийн найруулгад тодорхой өөрчлөлт гардаг.

Зөв сайхан найруулан бичнэ гэдэг нь илэрхийлэх гэсэн санаа бодол, юмс үзэгдлийг утга зохиолын хэлний хэм хэмжээнд бичнэ гэсэн үг юм. Энэ нь илэрхийлэх санаагаа ойлгомжтой, товч, тодорхой, үг сонголт, хэлзүйн арга хэрэглүүрийг зөв ашиглан найруулж бичихийг хэлнэ. Иймээс хэлний хувиргал нь хэлний нэгжүүдийг “хөдөлгөөнд оруулж”, харилцааны зорилго, холбосон орчинд нийцүүлэн, оновчтой найруулгаар илэрхийлж сургах хэрэглээний ач холбогдолтой юм.

Философийн танин мэдэхүйн үндсэн ойлголтод “Агуулга нь хэлбэрээр дамжин илэрдэг бөгөөд хэлбэр нь агуулгын гадаад байдал, зохион байгуулалт, түүний оршин тогтнох, илрэх арга юм. Нэг тодорхой юмс, үзэгдэл, үйл явц нэг

л агуулгатай байдаг боловч олон хэлбэрээр илэрч болдог.” (Содномгомбо, 2004, х.140) гэж тайлбарласан нь зөвхөн бодит юмс, материйн тухай биш, энэ нь хэлэнд ч хамааралтай асуудал бөгөөд, ялангуяа, хэлзүйн хувиргалтай холбоотой юм.

Хувиргал гэдгийг хэлшинжлэлийн нэр томъёоны лавлах толь бичигт “Трансформация (лат. transformation- преобразование, превращение)- это закономерное изменение основной языковой модели (ядерной структуры), приводящее к созданию вторичной языковой структуры. Трансформация действительной конструкции в страдательную (Ученик написал изложение.- Изложение написано учеником). Трансформация глагольной структуры предложения в именную (Дети вернулись из пионер лагеря.- Возвращение детей из пионерлагеря). Трансформация утвердительного предложения в отрицательное (В работе есть ошибки.- В работе нет ошибок). Трансформация повествовательного предложения в вопросительное (Брат был сегодня на работе.- Был ли брат сегодня на работе?” (Розенталь, 1976, х.49) гэж тодорхойлсон байна. 1950-иад оны сүүл үеэс товчоолох (дескриптив) хэлшинжлэлийн нэрт онолч З.Харрисын үндэслэсэн хэлшинжлэлийн хувьсах аргын тухай онолыг түүний шавь

\* ✉ tsedensurenouchimeg@yahoo.com

Н.Хомский үүсгүүр хэлзүйн хувьсах загвар (хэлийг загварчлах) болгон хөгжүүлж, “хувиргал хэлзүй” гэсэн нэр томъёог хэрэглэх болсон байна. Тэрээр, өгүүлбэрийн гүн бүтцэд тулгуурлан өгүүлбэрийн хувилбарыг тодорхой загвар (үйлдэл)-т оруулан гаргаж болно. Гүн бүтэц нь өнгөн бүтцээсээ илүү хийсвэр, нэгтгэн ерөнхийлсөн шинжтэй... Өнгөн бүтэц нь олон цуврал хувиргалтын үр дүнд бий болдог гээд хувиргалыг хэд хэдэн өгүүлбэрээр тайлбарлажээ (Гомбосүрэн, 2010, х.213).

### Судалгааны хэсэг

Эрдэмтэн М.Базаррагчаа “Цөм өгүүлбэрийн хувиргал (цөм цогцолбор) нь адилтгалд (дүрслэгт) өгүүлбэр, гүн өгүүлбэрийн хувиргал нь хүүрнэх, асуух, захирах өгүүлбэр болно. Энэчлэн гүн өгүүлбэр буюу тоочих найруулбарыг цагийн дараалалд тодорхой дүр, үйлдлээр хувиргавал хүүрнэх найруулбар, цөм өгүүлбэр буюу эргэцүүлэх найруулбарыг шинэ санаа бүхий учирзүйгээр дэлгэрүүлбэл нэрлэлт буюу тайлбарлах найруулбар болно. Өөрөөр хэлбэл, шууд бус нэрлэлт буюу найруулгын зогсонги шинжийг шууд хувиргаж болно” (Базаррагчаа, 2003, х.48) гэжээ.

Хэлний нэгжүүдийн хувиргалаар суралцагчдын найруулан бичих чадварыг хөгжүүлэхдээ хэлний түвшин, хувиргалын онцлогийг харгалзан уялдаа холбоотой тогтолцоот даалгаврыг гүйцэтгүүлэн, тэдэнд мэдээллийн цөм бүтцийг ухаарч ойлгох, нээлт хийх, өөрчилж хувиргах, оновчтой хувилбарыг сонгох, шийдэх боломж олгох нь чухал юм.

Ерөнхийлөх хувиргал (генерализация)- Энэ арга нь ихэвчлэн дээд түвшний их нэгжүүдэд хамаарах бөгөөд нийлмэл өгүүлбэр, эхийн гүн бүтэц буюу цөм санаа нь өнгөн бүтцийн өөрчлөлтийг даган хувирч байдаг онцлогтой. Иймд хэлбэр, хэв маяг, найруулгын бүтцээс шалтгаалан цөм санаа-онцолбор мэдээлэлд өөрчлөлт гардаг тул ерөнхийлөх хувиргал хэмээн үзэв.

Ерөнхийлөх хувиргал нь найруулан бичих үйлтэй ямар хамааралтай болохыг нягталж үзвэл:

#### Хүснэгт 1

Ерөнхийлөх хувиргал- найруулан бичих үйл

| Хувиргал   | Найруулан бичих чадвар                                                                                                                                    |
|------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Ерөнхийлөх | Эх, цогцолборын цөм бүтцийн утга санааг өөрчлөхгүйгээр хэв маягийг өөрчилж, утга, хэлбэрийн хувьд зөв хэлбэржүүлэн, холбон найруулж бичихийн үндэс болно. |

Эхийг ерөнхийлөн хувиргахад эхийн гол (цөм) санаа- гүн бүтэц тэр бүр өөрчлөгдөхгүй, харин хэлбэр, хэв маяг буюу өнгөн бүтэц нь өөрчлөгдөнө. Ийнхүү хувиргахдаа урвуулах (хураах, дэлгэрүүлэх), тонгоргох хувиргалыг хослуулж болдог байна.

### Судалгааны үр дүн

Эхийг ерөнхийлөн хувиргах аргаар суралцагчдын найруулан бичих чадварыг дэмжихэд дараах тогтолцоот даалгаврыг хийлгэсэн болно. Үүнд:

#### Алхам 1. Эхийн хэлбэрийг өөрчлөх

Эхийн цөм санааг хадгалан үргэлжилсэн үгээс шүлэглэсэн, шүлэглэснээс үргэлжилсэн үгийн хэлбэрт шилжүүлэн хувиргаж бичүүлэхэд урвуулах, салаалах, тонгоргох хувиргалыг цогц байдлаар хийх шаардлагатай болдог. Иймд ертөнцийн гурав, оньсого таавар зэрэг бичил эхээс эхлэн бүрэн хэмжээний эхэд тулгуурлан хувиргана.

#### Хаан ба зүүд тайлагч

Хаан нэг шөнө зүүдэндээ бүх шүд нь унаж, хоол ч идэж чадахгүй болж гэж зүүдэлжээ. Ууртайхан сэрж түшмэлээ дуудан ордны зүүд тайлагчийг яаралтай авчир хэмээн тушааж гэнэ. Нойрмог зүүд тайлагч ирэхэд хаан зүүдээ ярин асуух нь энэ зүүд сайны ёр уу муу ёр уу гэж асуужээ.

Зүүд тайлагч бага зэрэг бодсоныхоо дараа “” гэжээ. Хэсэг зуур нам гүм болсны дараа хаан уурлан үүнийг шоронд хорь, муу муу ёр хаантан минь та урт насалж бүх ойр дотныхоо хүмүүсийг хорвоогоос халихыг нь харж эцэст нь орь ганцаар үлдэх болно. Амтай зүүд тайлагч ямар байдгийг үз гэжээ. Зүүд тайлагчийг чирч гулдарсаар шоронд хорьж гэнэ.

Хаан өөр нэг зүүд тайлагч олж ир хэмээн тушаажээ.

Хоёр дахь зүүд тайлагч ирэхлээр нь хаан зүүдээ ярин асууж гэнэ. Хоёр дахь зүүд тайлагч бага зэрэг бодсоны дараа инээмсэглэн “сайны ёр хаантан минь, энэ зүүд таныг бусад төрөл төрөгсдөөсөө урт насалж олон жил улс орноо удирдахыг харуулж байна.” гэв. Хаан түшмэлийн чихэнд шивнэн энэ зүүд тайлагчид хоёр алтан зоос өг гэжээ.

Энэ үйл явдлыг эхнээс нь дуустал үзэж байсан хүмүүс түүнээс асууж гэнэ. Угтаа та ч гэсэн өмнөх зүүд тайлагчтай адилхан зүйл хэлсэн, яагаад түүнийг шийтгэж, таныг шагнав?

Тийм ээ, бид адилхан л зүйл хэлсэн. Гэхдээ чухал юм гэвэл, зарим хүмүүст юу хэлэх нь чухал биш, яаж хэлэх нь чухал гэжээ.

## Оюутнуудын хувирган найруулсан нь:

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>Хувилбар А<br/> Хаан ба зүүд тайлагч<br/> Урьд шөнө хаан<br/> Учиртай нэгэн зүүд зүүдэллээ.<br/> Бүх шүд нь унаад<br/> Бүр хоол ч идэж чадахгүй байна гэж.<br/> Бухимдаж сэрсэн хаан<br/> Бушуухан зүүд тайлагчаа дуудуулж гэнэ<br/> Зүүд юуг зөгнөв<br/> Зөв бурууг хэлээд аль гэвэл<br/> Эхний зүүд тайлагч<br/> Ээрэн сандран байж<br/> Энэ бол муу ёр шүү<br/> Ойр дотны хүмүүсээ алдаад<br/> Орь ганцаар үлдэнэ гэвэл<br/> Хааны уур хилэн хүрч<br/> Хурдхан түүнийг хорь гэв.<br/> Дараах зүүд тайлагч<br/> Даруухан царайндаа инээмсэглэл тодруулан<br/> Ямар сайхан зүүд вэ<br/> Яахын аргагүй урт наслахын зөн гэвэл<br/> Хааны сэтгэл тайвширч<br/> Хоёр алтан зоос хайрлав гэнээ.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | <p>Хувилбар Б<br/> Ямбат нэгэн хаан<br/> Яралзсан цагаан шүдээ<br/> Унаж байна гэж<br/> Удаан гэгч зүүдэлжээ<br/> Ууртай сэрсэн хаан<br/> Учир битүүлэг зүүдээ тайлах гэж<br/> Ордны зүүд тайлагчийг олж ир гэж тушаав.<br/> Орж ирсэн зүүд тайлагчид<br/> Омогт хаан зүүдээ ярилаа<br/> Мунхаг зүүд тайлагч<br/> Муу ёр хэмээн шулуухан хэлэхэд<br/> Шар нь гозойсон хаан<br/> Шадар түшмэлдээ түүнийг<br/> Шоронд хорь хэмээн тушаажээ.<br/> Өөр зүүд тайлагч ол гэж<br/> Өөдгүй хаан уурлажээ.<br/> Зүүд тайлагч ирээд<br/> Зөгнөн хэлэхийн өмнө<br/> Зөв бурууг тунгаан<br/> Зүүд тань сайны ёр.<br/> Хаан та урт насалж<br/> Хамаг улсаа удирдахыг<br/> Харуулсан зүүд бөлгөө гэв.<br/> Хаан түүнийг бэлгэшээн<br/> Хоёр алтан зоосоор шагнав.<br/> Энэ явдлыг харсан хүмүүс<br/> Ихэд гайхаж байв гэнэ.</p>             |
| <p>Хувилбар В<br/> Хатмал цөлд явахад хар ус амттай<br/> Харанхуй шөнийн дунд өнчин зүүд гунигтай<br/> Хан буурал хорвоогийн эргэн хувьсах жамаар<br/> Хаан нэгэн шөнө<br/> Хар дарж сэрлээ.<br/> Хачин их ууртай босож<br/> Хамаг түшмэлдээ дуудав.<br/> Амаар дүүрэн аржгар хурганы арьс<br/> Алга дүүрээд уначихлаа гэж зүүдэлжээ.<br/> Сайн сайхныг бэлгэдэн зүүдлэв үү<br/> Саар мууг зөгнөн зүүдлэв үү гэсэнд<br/> Мэргэд бүхний дээд<br/> Мэлмий тунгалаг зүүд тайлагч<br/> Ухаан бодлоо төвлөрүүлэн<br/> Ууртай хааны уцаарлан асуусанд<br/> Тунгаан бодож тулгамдан хариулсан нь<br/> Саарыг зөгнөсөн ажгуу<br/> Санасан бүхэн чинь биелэхгүй<br/> Садан бүхэн чинь насан эцэслэж<br/> Орчлонд та орь ганцаараа үлдэж<br/> Одод тэнгэрийн дор уйтгар гунигийн эзэн<br/> болно гэлээ.<br/> Огт санаанд минь нийцсэнгүй<br/> Онцгүй зүүд тайлагч байна.<br/> Одоохон хорь гэж<br/> Омог ихтэй хаан зарлиг буулгалаа<br/> Ахиад нэг зүүд тайлагчийг авчирч<br/> Асуун лавлахад<br/> Аятайхан инээмсэглэн<br/> Аядуухнаар хариулсан нь<br/> Сайныг бэлгэдсэн ажгуу<br/> Санасан бүхэн чинь биелж<br/> Урт насалж удаан төрийг барьж<br/> Таны таньж мэддэг хүмүүс<br/> Танихгүй хүмүүс болсон байна гэсэнд<br/> Агуу их хаан<br/> Амны бэлэгтэй зөнчид<br/> Алтан зоос хоёрыг өг гэвээ.<br/> Үгийн шид энэ буюу.</p> | <p>Хувилбар Г<br/> Хаан нэгэн өдөр хачин жигтэй зүүд зүүдэлжээ<br/> Хавь ойрын хүнийг дуудан<br/> Хамгийн сайн зүүд тайлагчийг авчруулж<br/> Хачирхалтай зүүдээ ярьж эхлэв<br/> Харин түүнийг сонссон зүүд тайлагч<br/> Хаантан та орчлон дэлхий дээр орь ганцаар үлдэж<br/> Хамаг бүхнээсээ хагацахад хүрэх нь ээ гэж.<br/> Хаантан хилэгнэн уурлаж<br/> Хар гэрт хорь гэж тушаав<br/> Сэтгэлээр унасан хаантан<br/> Сэм сэмхэн санаа алдаж<br/> Сэтгэлийг минь тайтгаруулах зөнчийг авчир гэв<br/> Сэм сэмхэн алхсаар дараагийн зөнч орж ирэв.<br/> Хаантны хачирхалтай зүүдийг сонсоод<br/> Хаантан та орчлон дэлхий дээр урт насалж<br/> Хаан сэнтийдээ удаан залрах нь ээ<br/> Үүнийг сонссон хаантан ихэд баярлаж<br/> Үлэмж ихийг түүнд өгөв<br/> Үгийн ид шидийг ухаарч<br/> Үр хойчид сургамжлан үлдээсэн гэдэг.</p> |

Алхам 2. Утга, хэлбэрийг дуурайн зохиох

Санаа нь чинжүү сахал нь туужуу

Хэлбэрээрээ: Санаа нь дэлхий

Чадал нь мэлхий шиг

(тэй адил, мэт)

Утгаараа: Санаа гэж собака

Санаа гэж сармис

Санаа гэж чинжүү

Бичил эхийн хэмжээнд, ялангуяа, шүлэглэсэн хэлбэртэй эхийг утга санааг нь алдагдуулахгүйгээр зохион бичихэд дөхөм байх тул оюутнууд хялбархан зохиож байна. Иймээс энэ чадварт нь тулгуурлан үргэлжилсэн үгийн, хэмжээний хувьд арай том эхийг дуурайлган зохиолгоно. Жишээ нь:

Дуурайх эх нь: Хүйн холбоо

Модод навчаараа уйлдаг гэж өвөө минь надад нэгэн цагт хэлж билээ. Гэвч энэ үгийн утгыг би их л хожуу ухаарсан юм даа. Тэр нэгэн өдөр өвөөгөө дагаж явсаар нэгэн бүдүүн хайлаас модны дэргэд очиж билээ. Өвөө минь энэ хайлаас бид хоёр ихэр юм шүү дээ. Үүнийг би багадаа тарьж ургуулсан юм хэмээн баясгалантай өгүүлж билээ. Өвөөгөө үүрд алдсан намрын жихүү даасан зэврүүн саарал өдөр өнөөх хайлаасны дэргэд ганцаар очиход өнөөх мод амьдрал минь дууслаа гэх шиг хатаж шарласан навчсаа нэг нэгээр нь уйтайнхан тасдан хаяж байсан юм. Хөгшин хайлаас эрүү өвдөг нь нийлсэн өвгөн хоёр хүй нэгтэй байсныг тэгэхэд би ойлгосон юм. Хүн байгаль хоёр хүйн холбоотой гэдэг энэ байх даа. Гэвч хаврын ирж яваа улиралд энэ хайлаас баясгалантайгаар навчлан ургахын адил миний дотор өвөөгийн минь амьд ахуйн дүр амилж, сэтгэлд минь мөнх орших ажгуу.

Оюутан А

Амин холбоо

Хүн байгаль хоёр амин холбоотой гэдгийн учрыг би ойлгодоггүй байлаа. Нэгэн удаа үл таних хөгшин надад “мод навчаараа уйлдаг юм.” гэж хэлж билээ. Энэ үгийн утгыг би хожуу ухаарсан юм. Тэр нэгэн өдөр хөгшнийг даган явсаар бүдүүн хайлаас модны дэргэд хүрч очиж билээ.

“Энэ хайлаас бид хоёр ихэр юм шүү дээ. Үүнийг багадаа тарьж ургуулсан юм” хэмээн өгүүлж билээ. Түүнээс хойш тэр хөгшин нас нөгчиж, намрын жиндүү даасан зэврүүн саарал өдөр өнөөх хайлаасны дэргэд очиход амьдрал минь дууслаа гэсэн шиг хатаж шарласан навчис нь нэг нэгээрээ уйтайнхан унаж байсан юм. Хөгшин хайлаас, эрүү өвдөг нь тулсан хөгшин хоёр хүй нэгтэй байсныг тэгэхэд л би ойлгосон юм.

Оюутан Б

Хүйн холбоо

Эмээ минь надад байнга хэлдэг байсан сан. Ээж чинь, чи, бид гурав гуравласан холбоотой гэж. Тэр үед би ухаараагүй өнгөрчээ. Нэгэн өдөр намайг өвдөхөд ээж минь яг над шиг өвдөж билээ. Яагаад бие нь ингэж өвдөж байгааг асуухад: “Эмээ чинь чамд дандаа хэлдэг байсан даа. Хүн амьтан бүгд эхээс төрөхөд хүйгээр холбогдож төрдөг учраас чамайг өвдөж зовоход ээж нь бодол санаа, зөн совингоороо аль хэдийн мэдчихсэн шаналж байдаг юм.” гэж билээ. Тэгэхэд л би эмээгийнхээ хэлдэг байсан гуравласан хүйн холбоо гэдгийг ухаарч ойлгосон юм.

Мөннайрууланбичихчадварыгхөгжүүлэхийн тулд бичил эхийн санаа, хэлбэрийг хувирган өөрчлөх дадлага чухал байдаг. Тийм учраас дараах эхийг сонгон утга санаа, хэв маягийг ерөнхийлөн найруулж бичүүлэхэд суралцагчид сонирхолтой хувилбарыг гаргаж чадсан юм.

Харгай заг хоёр

Эрт урьд харгай, заг хоёр нутаг булаалдаж тэмцэлдээд, харгай нь дийлээд хангайд нутаглах болж, заг модыг говь руу хөөчихсөн юм гэнэ.

Гэсэн ч уулын орой хяраар харгай мод эрвэн сэрвэн ургасан байдаг нь заг ирж магадгүй гэж харуулдаж, харж байдгийнх гэнэ. Уулын араар ургасан жижиг модыг харгайн хүүхдүүд гэдэг байна.

Харгай модны яр нь хадаас нэвт нэвт шаасан юм шиг байдаг нь загийн харвасан сум түүний биед үлдсэн нь тэр гэнэ.

|                                                                                                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>Оюутан А<br/>(хэлбэрийг өөрчлөн цөм санааг хадгалан бичих)<br/>Эрт урьд биш гэнэ.<br/>Эдүгээ үеийн цагт гэнэ.<br/>Харгай заг хоёр харгалдан<br/>Хангай нутгийг булаалдаж гэнэ.<br/>Хар санаат харгай дийлж<br/>Хөөрхий загийг говь руу хөөж гэнэ.<br/>Тэр цагаас хойш<br/>Бие биеэ хараагүй юм гэнэ дээ.</p> | <p>Оюутан Б<br/>(цөм санааг дуурайлган бичих)<br/>Урьд эрт цагт юм гэнэ.<br/>Энэ манай нутагт юм гэнэ.<br/>Мазаалай баавгай хоёр<br/>Маш дотно найзууд байжээ.<br/>Гэтэл нэгэн өдөр тэр хоёр<br/>Газар нутгаа булаалдан тэмцэлджээ.<br/>Хамаг хүч чадлаараа<br/>Халз тулаанд оржээ.<br/>Олон өдөр тулалдаж<br/>Онцолж баавгай ялж<br/>Олиггүй зантай мазаалайг<br/>Ойгоос цөл рүү хөөжээ.<br/>Тэр цагаас хойш<br/>Тэр хоёр бие биетэйгээ тааралдаагүй юм гэнэ билээ.</p> |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Ийнхүү эхийн цөм санааг хадгалан, хэв маяг, хэлбэрийг нь хувиргаж бичсэнээр суралцагчид монгол шүлгийн уламжлал болох толгой сүүл холбох, мөр доторх үгийн тоог тэгшитгэх, хэмнэл тааруулах, дүрслэх ур маягийг оновчтой сонгон хэрэглэж чаддаг болж байна. Тухайлбал:

Ойр дотны хүмүүсээ алдаад  
Орь ганцаар үлдэнэ гэвэл  
Хааны уур хилэн хүрч  
Хурдхан түүнийг хорь гэв.  
Дараах зүүд тайлагч  
Даруухан царайндаа инээмсэглэл тодруулан  
Ямар сайхан зүүд вэ  
Яахын аргагүй урт наслахын зөн гэвэл  
Хааны сэтгэл тайвширч  
Хоёр алтан зоос хайрлав гэнээ гэхэд  
“ООххДДяаХХ” гэж хос хосоор нь толгой,  
Шадар түшмэлдээ түүнийг  
Шоронд хорь хэмээн тушаажээ.  
Өөр зүүд тайлагч ол гэж  
Өөдгүй хаан уурлажээ гэж 2, 4-р мөрийг –жээ  
бүтээврээр сүүл холбон,  
Ууртай хааны уцаарлан асуусанд  
Тунгаан бодож тулгамдан хариулсан нь  
зэргээр мөр доторх үгийн тоог  
тэгшитгэн, нийлмэл үгийг оновчтой сонгож,  
шүлгийн хэмнэлийг тааруулж чадсан зэрэг нь  
өвөрмөц болжээ.  
Харин “шар нь гозойх”, “мэлмий тунгалаг”,  
“өнчин зүүд” зэргээр чимэг үг сонгосныг эс  
тооцвол дүрслэх ур маягаас найруулан бичих нь  
бага байна.

Хатмал цөлд явахад хар ус амттай  
Харанхуй шөнийн дунд өнчин зүүд гунигтай  
Хан буурал хорвоогийн эргэн хувьсах жамаар  
Хаан нэгэн шөнө  
Хар дарж сэрлээ.

Ийнхүү ерөнхийлөн хувиргахдаа дүрслэх ур маяг (тропы)-аас аль болохоор сонгон, яруу сайхан найруулан бичихэд анхаарна.

Алхам 3. Эхийн хэв маягийг өөрчлөн  
Эхийн хэв маягийг өөрчлөн бичих нь суралцагчдаас бүтээлчээр сэтгэх чадварыг шаардана.

#### Ямааны мах (тайлбарламж)

Энэхүү хэвшмэл хэлц нь монголчуудын анагаах ухааны мэдлэгээс эх үүсвэртэй бөгөөд ямааны мах нь хүйтэн чанартай тул хөрөх, царцахдаа амархан, хүйтнээр нь идвэл ходоодонд шингэхдээ муу, гэдэсний арван хоёр нугалаанд царцаж түгжрэл болох өвчний гэмтэй гэдэг. Тиймээс монголчууд ямааны махыг халуун дээр нь идэж, халуун цай даруулж уудаг заншилтай. Дээрх хэвшмэл хэлцтэй утга дүйх өөр нэг хэллэг бол “ямааны мах янтай” гэсэн үг юм. Ян - хууч өвчнийг хэлнэ. Ямааны мах хүний хууч өвчнийг хөдөлгөж сэдэрэх тул ялангуяа хөгшин настай хүн идэхийг цээрлэдэг бас нэг заншил буй бөлгөө (Бат-Ирээдүй, 2007).

Хувиргасан нь:

Оюутан А (тоочимж)

Ямааны мах нь:

хүйтэн чанартай, хөрөх царцахдаа амархан  
хүйтнээр нь идвэл шингэхдээ муу, түгжрэл  
болох гэмтэй.

халуун байхад нь идэж, халуун цай даруулж  
ууна.

Хууч хөдөлгөх тул хөгшин хүн идэхийг  
цээрлэнэ.

Оюутан Б (хүүрнэмж)

Ямааны мах нь хүйтэн чанартай, хууч  
өвчнийг сэдэрээдэг. Монголчуудын анагаах ухааны  
мэдлэгээс эх үүсвэртэй ямаатай холбоотой  
“ямааны мах халуун дээрээ, ямааны мах янтай”  
зэрэг хэллэгүүд байдаг.

Эхийн хэв маягийг өөрчлөн бичихэд

Алхам 4. Эхийн хэв маяг, хэлбэрийг өөрчлөн  
найруулан бичих

Сурах бичигт уламжлалт бичгийн хэлний эхийн (“Бага хөвүүнийг удирдан заах сургаал”) найруулгыг өнөө цагийн өнгө аястай болгон хувиргаж найруулах, “Баянбүрд” туужийн баатар эрдэмтэн Батнасангаас ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар хаягласан өргөдлийг албан тодорхойлолт болгон хувиргаж бичих, “Монголын нууц товчоон”-ы 149 дүгээр зүйлд Урианхайн Зэлмэ хүлэг баатрын тухай магтаал шүлгийг тоочимж тодорхойлолт болгон хувиргаж бичсэн зэрэг

сонирхолтой, бүтээлч шинж бүхий дасгал даалгаврыг аргачлалын дагуу гүйцэтгэх нь сурагчдын найруулан бичих чадварын хөгжилд ихээхэн тус нэмэртэй юм.

Даалгавар нь: Зохиолын баатрын хэлсэн үг, хам сэдэвт тулгуурлан хэв маягийг өөрчлөн бичих а. “Монголын нууц товчоо” зохиолын Чингисийн есөн өрлөгөө магтсан магтаалыг тодорхойлолт болгон өөрчлөн найруулж бичих

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>Зэлмийн хэлсэн үг:<br/>         Үхэх амиа хайрлахгүй<br/>         Үгүйрэх малаа харамлахгүй<br/>         Үзэгдэх дайсныг халтиртал дайрч<br/>         Замдаа тохиолдсоныг<br/>         Зад цохиж<br/>         Мөртөө тохиолдсоныг<br/>         Мөлт цохиж...<br/>         ...Дайсны сүрийг даран сөнөөж<br/>         Дахин босох чадлыг нь мөхөөе.<br/>         (Ц.Дамдинсүрэн, “МНТ”, 2004. 110-р тал)</p> | <p>Чингисийн магтсан нь:<br/>         Ороо гөрөөсний отлого болсон<br/>         Омогт дайсны зүрхийг чичрүүлсэн<br/>         Унах морьгүй болоход<br/>         Унаа авчирч өгсөн<br/>         Ундаасан цангах цагт<br/>         Уух дарс өгсөн<br/>         Сэргэг бага нойртой<br/>         Цэцэн мэргэн ухаантай<br/>         Улс төрийн төлөө<br/>         Урьд цагаас зүтгэсэн<br/>         Урианханы сайн Зэлмэ минь (115-р тал)</p> |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Оюутны тодорхойлолт болгон хувирган найруулж бичсэн нь:

Оюутан А

Зэлмэ нь тууштай, үнэнч сайн цэрэг байхын зэрэгцээ бусдад анд нөхөр нь байж чаддаг. Улс эх орныхоо болон анд нөхдийнхөө төлөө амиа үл хайрлан тулалддаг зоригтой, дайчин эр юм.

Оюутан Б

Зэлмэ нь тусч сэтгэлтэй, үнэнч шударга, аливаад хүлээцтэй уужуу ухаанаар хандаж чаддаг эрт цагийн баатар эр юм.

Оюутан В

Ороо гөрөөсний отлого болж, омогт дайсны зүрхийг чичрүүлж, унах морьгүй болоход унаа авчирч, ундаасан цангах цагт уух дарс өгсөн, сэргэг бага нойртой, цэцэн мэргэн ухаантай, улс төрийн төлөө зүтгэсэн учир Урианханы сайн Зэлмэ гэж тодорхойлов.

б. Өргөдлийг тодорхойлолт болгон найруулж бичих

Би идэр наснаасаа говьд сэтгэл зүрхээ тушаасан хүн. Говийг ганцаараа аврах ч юм уу монголын туршлага гэдгийг ганцаараа биелүүлж чадах мэдлэг чадвартай хүн гэж өөрийгөө өчүүхэн ч үзэхгүй байна.

Гэхдээ эрдэмтний хувьд говийн байгаль баялгийг хамгаалах хэрэгт чадлын хэрээр зүтгэх, говийн баялгийг хувирган сайжруулах арга замыг туршлагын журмаар судлах, говийн ус, хөрс, ургамал, цаг уурын өөрчлөлт зэрэгт ажиглалт судалгаа хийх бодолтой байна.

Говийг амархан өөрчилж болох мэтээр хоосон төлөвлөгөө зохиож байсан өнгөрчээ. Одоо ажиллах цаг ирсэн.

Тиймээс ШУА-ийн газарзүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан Батнасан намайг одоо эрхэлж буй ажлаас чөлөөлж говь руу явуулж өгөхийг хүснэ. (С.Эрдэнэ “Баянбүрд” туужаас)

Хувирган найруулж бичсэн нь:

Оюутан А

.....овогтой Батнасан нь ШУА-ийн газарзүйнхүрээлэндажилладаг. Тусбайгууллагад олон жил ажилласан, туршлагатай, залуучуудыг ажил үйлсээрээ үлгэрлэн манлайлдаг.

Тэрээр ажилдаа сонирхолтой, шинэ санаа байнга эрж хайдаг, ажлыг чанартай хийж гүйцэтгэхийг эрмэлздэг манай тэргүүний ажилтны нэг юм.

Оюутан Б

Батнасан нь тус байгууллагад олон жил ажиллаж байгаа туршлагатай ажилтны нэг юм. Тэрээр говийн бүсийн байгалийн баялгийг хамгаалах талаар судалгаа шинжилгээний ажлыг тасралтгүй хийж, энэ талаар шинэ санаа, шинэ бүтээл гаргаж байсан болно.

Оюутан В

ШУА-ийн газарзүйн хүрээлэнгийн ахлах ажилтан Батнасан нь говь нутагт хайртай, идэр наснаасаа сэтгэл зүрхээ өгсөн хүн юм. Төлөв даруу, шинийг эрэлхийлэгч.

Тэрээр говийн байгаль баялгийг хамгаалах, хувирган сайжруулах арга зам, говийн ус, хөрс, ургамал, цаг уурын өөрчлөлт зэрэгт ажиглалт судалгаа хийж байгаа бодитой, хүсэл эрмэлзэлтэй хүн юм. Иймээс эрдэмтэн Батнасанг одоо эрхэлж буй ажлаас нь чөлөөлж говь нутагт ажиллахыг зөвшөөрсөн болно.

Оюутан Г

Батнасан нь ШУА-ийн газарзүйн хүрээлэнд олон жил ажилласан, туршлагатай. Байгалиа хамгаалах сэтгэлтэй, шулуун шударга зантай, хийж бүтээх сэтгэлгээтэй, төлөв даруу, манай ахмад ажилтны нэг юм.

Оюутан Д

Батнасан нь Шинжлэх Ухааны Академийн газар зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан бөгөөд эрдэм шинжилгээний ажлуудынхаа нэлээд хувийг говь нутгийг судлахад зориулсан хүн билээ. Эрдэмтнийхээ хувьд говийн байгаль, баялгийг хамгаалах үйл хэрэгт зүтгэх туйлын зорилго тээж явдаг. Тэрээр эрхэлж буй ажил мэргэжилдээ чин сэтгэлээсээ ханддаг, хариуцлагатай, шинийг санаачлагч хүн юм.

Ерөнхийлөн хувиргах тогтолцоот даалгаврыг хийлгэхэд:

| Дадлага ажлын явцад оюутнуудын гаргаж байсан нийтлэг алдаа                                                                                                                                                                                                                    | Багшийн анхаарах зүйл                                                                                                                                                         | Оюутнуудад гарсан ахиц                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Эхийн хэв маяг, найруулгын төрлийг өөрчлөн бичихдээ эхний үед үг, холбох хэрэглүүрийг оновчгүй сонгох<br>Дүрслэх ур маягийг ашиглахгүй, энгийн үг хэллэгээр бичих<br>Эхийн гол санааг анхаарахгүй байх<br>Хувирган найруулж бичихийн мөн чанарыг ухаараагүйгээс хайнга хандах | Эхийн хэв маягийн ялгамжийг гаргаж чадаж байгаа эсэх<br>Дүрслэх ур маягийг ашиглаж байгаа эсэх<br>Ерөнхийлөн хувиргахад зөвхөн хэлбэрийг дуурайх биш гол санааг хадгалж бичих | Эхийн хэв маяг, найруулгын төрлийн тухай ойлголтыг хэрэглээ талаас нь ухаарч таньсан.<br>Үг, холбох хэрэглүүрийг эхийн хэв маяг, найруулгын төрөлд тохируулан сонгох чадварт өөрчлөлт гарсан.<br>Хэрэглээний эх бичвэр болон зохиолын баатрын хэлсэн үгийг хам сэдэвт нь тулгуурлан гол санааг хадгалан тодорхойлолт болгон хувирган найруулж бичих чадварт суралцсан. |

## Дүгнэлт

Хэлний нэгжүүдийн утгат хэсгийг хувирган өөрчлөх, ялангуяа, эхийн хэв маяг, хэлбэр, найруулгын төрлийг өөрчлөн найруулах дасгал даалгаврыг алхам алхмаар хийлгэсний үр дүнд дараах ахиц ажиглагдаж байна.

Эхийн найруулгын төрөл, хэв маяг, төрлийг өөрчлөх, дуурайн зохиох нь нэг талаас зохион бичих гол суурь болох, нөгөө талаас бусад хувиргах аргуудыг хослуулан хэрэглэх тул суралцагчдаас бүтээлчээр сэтгэх чадвар, хэлний мэдрэмжийг шаардана.

Суралцагчдын үг хэллэгийн нөөц баяжиж, холбох хэрэглүүрийг оновчтой сонгох, өгүүлбэр, эхийг дэлгэрүүлэн, хураан товчилж, уншсанаа ухаарч ойлгох чадварт суралцаж, улмаар эх зохион бичих чадвартай болж байгаа нь хувиргалын сургах зүйн ач холбогдлыг илтгэж байна.

Хэлний нэгжүүдийг хувиргаж сурснаар суралцагчдын бүтээлчээр сэтгэх чадвар (нэгээс нөгөөд хурдан шилжих, ажиглах, олон талаас нь тунгаан бодох, чухал хувилбарыг оновчтой сонгох, түргэн зөв сэтгэх), зөв, оновчтой найруулан бичих чадвар хөгжиж байгааг оюутны найруулан бичих чадварын өөрчлөлт харуулж байна.

## Ашигласан материал

- Базаррагчаа, М. (2003). Монгол хэлний сүегэр ба найруулбарын тухай. Улаанбаатар
- Бат-Ирээдүй, Ж. (2007). Монгол хэлний хэвшмэл хэллэг дэх хэлц үгийн утга. Улаанбаатар
- Гомбосүрэн, Ц. (2010). Хэлний философи ба хэлшинжлэлийн (лингвистик) философи. Улаанбаатар
- Дамдинсүрэн, Ц. (2004). Монголын нууц товчоо. Улаанбаатар
- Розенталь, Д.Э., Теленкова, М.А. (1976). Словарь-справочник лингвистических терминов. Москва
- Содномгомбо, Д., Дарьхүү, Р. (2004). Философи. Улаанбаатар

## Correlations between generalization and composition skills

*Ц.Оюунчимэ*  
*Mongolian National University of Education,*  
*Arkhangai Teacher's School, Humanities Department*

---

### Abstract

When we develop learners' composition skills through transformation of language units, it is important to give possibilities to understand the core structure of information, to invent, to change and to decide choosing the optimal variation by making learners perform logic assignments step by step looking at language levels and characteristics of transformation.

Composing correctly and accurately is to write ideas to express and descriptions of items in the norms of literary language. It can also be writing and composing ideas clearly and briefly while choosing the correct word and proper use of grammar units. So, language transformation "makes language units move" and it has usage importance to train learners express ideas in rational composition in accord with connecting environment and communication goals.

Generalization is a method that usually concerns high level units, and the meaning or core idea of a composite sentence and a text has characteristics that transfers according to changes of an external structure. So, we discussed it generalization, because of changes that occur in the core idea-special information depending on forms, styles, and stylistic structures.

In this study, we made experiment of structured assignments based on generalization to support students composing skills. These assignments require creative thinking and language feelings because kinds of text stylistics, models, changing kinds, and simulating becomes main background from one side, and use a combination of other transformation methods from other side.

### Key words

Generalization, composition skills, text form, style